

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/172/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ОТГОН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ А.СОСОРБУРАМ-д

2022.02.24 № 1302/224
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгон сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Хүснэгт 3
Огноо: 2022.02.24
Хийгэгч: Д.Бат-Ундраа
Боловруулсан: Д.Бат-Ундраа

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Даясны код	Балаасын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,044,331.06	12,338,866.54
33	АВЛАГА	519,903.06	237,208.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	519,903.06	237,208.54
35	БАРАА МАТЕРИАЛ	9,524,428.00	12,101,658.00
351	Түүхий эд материал	-	1,706,250.00
35110	Тусгай зориулалттай материал	-	1,706,250.00
354	Хангамжийн материал	9,524,428.00	10,395,408.00
35410	Бичиг хэргийн материал	57,000.00	66,000.00
35420	Аж ахуйн материал	2,416,888.00	2,376,388.00
35440	Түлш, шатах тослох материал	1,980,000.00	2,501,000.00
35450	Барилгын засварын материал	853,400.00	852,400.00
35470	Бусад хангамжийн материал	4,217,140.00	4,599,620.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	74,384,197.41	63,383,821.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	74,384,197.41	63,383,821.86
392	Биет хөрөнгө	71,820,197.41	60,819,821.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	55,354,324.48	55,354,324.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,815,521.20)	(23,723,281.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,147,946.70	47,447,946.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,584,686.86)	(38,294,872.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,347,344.00	12,347,344.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,549,489.71)	(10,588,219.26)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,072,300.00	2,082,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,314,160.00	4,314,160.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,314,160.00)	(4,314,160.00)
39217	Ном	15,847,980.00	16,194,280.00
393	Биет бус хөрөнгө	2,564,000.00	2,564,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,564,000.00	2,564,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	84,428,528.47	75,722,688.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	84,428,528.47	75,722,688.40
51	Засгийн газрын хувь оролцоо	84,428,528.47	75,722,688.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,935,427.70	45,935,427.70
51101	Өмч: - төрийн	45,935,427.70	45,935,427.70
512	Хуримтлагдсан үр дүн	(17,671,978.71)	(26,377,818.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(17,671,978.71)	(17,671,978.71)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,705,840.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,165,079.48	56,165,079.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	84,428,528.47	75,722,688.40

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	28,706,400.00	68,120,350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	3,536,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	3,536,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	3,536,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	203,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	3,332,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,606,400.00	64,584,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	28,606,400.00	64,584,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,606,400.00	64,584,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,477,419.32	76,826,190.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,477,419.32	76,826,190.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,477,419.32	76,801,232.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,949,158.00	45,834,436.00
210101	Үндсэн цалин	21,949,158.00	41,331,836.00
210102	Нэмэгдэл	-	4,502,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,557,445.00	5,276,258.52
210201	Тэтгэрийн даатгал	1,865,679.00	3,484,958.52
210202	Тэтгэмжийн даатгал	219,492.00	447,800.00
210203	ҮОМШЭ-ний даатгал	175,593.00	358,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	25,870.00	89,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	270,811.00	895,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	299,896.00	9,824,102.00
210301	Гэрэл, цахилгаан	44,896.00	505,102.00
210302	Түлш, халаалт	255,000.00	9,259,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,400.00	694,000.00
210401	Бичиг хэрэг	-	57,000.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	208,000.00
210403	Шуудан, холбоо, интернэцийн төлбөр	78,400.00	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	224,000.00
2105	Нормативт зардал	95,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	451,000.00
210604	Урсгал засвар	-	451,000.00
2107	Төмнөлт, зочны зардал	47,000.00	281,000.00
210701	Гадаад албан төмнөлт	-	-
210702	Дотоод албан төмнөлт	47,000.00	281,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	469,200.00	1,783,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	388,200.00	1,662,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэргэлэл тогтоох	81,000.00	121,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,861,320.32	12,656,675.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	5,861,320.32	12,656,675.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	24,958.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	24,958.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,958.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,771,019.32)	(8,705,840.07)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,771,019.32)	(8,705,840.07)

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(6,206,936.13)	95,893,571.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(6,206,936.13)	95,893,571.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,771,019.32)	(2,771,019.32)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(17,671,978.71)	84,428,528.47
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(17,671,978.71)	84,428,528.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(17,671,978.71)	84,428,528.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,705,840.07)	(8,705,840.07)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,935,427.70	56,165,079.48	(26,377,818.78)	75,722,688.40

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	46,475,300.00	64,787,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	203,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	203,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	203,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	203,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,375,300.00	64,584,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	46,375,300.00	64,584,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	46,375,300.00	64,584,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	41,448,602.00	64,757,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,448,602.00	64,757,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,448,602.00	64,732,842.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,404,235.00	44,782,400.00
210101	Үндсэн цалин	30,239,415.00	40,279,800.00
210102	Нэмэгдэл	3,164,820.00	4,502,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,534,200.00	6,045,600.00
210201	Тэтгэрийн даатгал	3,190,500.00	4,254,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	335,700.00	447,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	261,600.00	358,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	75,000.00	89,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	671,400.00	895,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,222,417.00	10,215,102.00
210301	Гэрэл, цахилгаан	101,317.00	505,102.00
210302	Түлш, халаалт	2,121,100.00	9,650,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	60,000.00
2104	Хавгамж, бараа материалын зардал	317,550.00	627,900.00
210401	Бичиг хэрэг	89,150.00	66,000.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	239,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	108,400.00	234,500.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, акуйн эд зүйлс	-	87,900.00
2105	Нормативт зардал	95,000.00	95,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,000.00	95,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,000.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	111,000.00	-
210604	Урсгал засвар	-	450,000.00
2107	Томилголт, зочны зардал	47,000.00	281,000.00
210702	Дотоод албан томилголт	47,000.00	281,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	717,200.00	2,031,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	636,200.00	1,910,240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	81,000.00	121,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	203,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	203,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	24,958.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	24,958.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,958.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,026,698.00	30,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	30,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	30,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	30,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	30,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(30,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,026,698.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсийн үлдэгдэл	5,026,698.00	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,584,300.00	64,559,342.00	24,958.00	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,584,300.00	64,559,342.00	24,958.00	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,584,300.00	64,559,342.00	24,958.00	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,782,400.00	44,782,400.00	-	100%
210101	Үндсэн цалин	40,279,800.00	40,279,800.00	-	100%
210102	Нэмэгдэл	4,502,600.00	4,502,600.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,045,600.00	6,045,600.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	4,254,300.00	4,254,300.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	447,800.00	447,800.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	358,300.00	358,300.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	89,600.00	89,600.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	895,600.00	895,600.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,227,800.00	10,215,102.00	12,698.00	100%
210301	Гэрэл, шахилгаан	515,700.00	505,102.00	10,598.00	98%
210302	Түлш, халаалт	9,652,100.00	9,650,000.00	2,100.00	100%
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	60,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	657,900.00	657,900.00	-	100%
210401	Бичиг хэрэг	63,000.00	66,000.00	(3,000.00)	105%
210402	Тээвэр, шатахуун	239,500.00	338,000.00	(98,500.00)	141%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235,400.00	136,000.00	99,400.00	58%
210404	Ном, хэвлэл	60,000.00	30,000.00	30,000.00	50%
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00	87,900.00	(27,900.00)	147%
2105	Нормативт зардал	95,600.00	95,600.00	-	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,600.00	95,600.00	-	100%
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	450,000.00	450,000.00	-	100%
210604	Урсгал засвар	450,000.00	450,000.00	-	100%
2107	Төмлөлт, зочны зардал	281,700.00	281,000.00	700.00	100%
210702	Дотоод албан төмлөлт	281,700.00	281,000.00	700.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,043,300.00	2,031,740.00	11,560.00	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,913,300.00	1,910,240.00	3,060.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	130,000.00	121,500.00	8,500.00	93%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,584,300.00	64,584,300.00	-	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,584,300.00	64,584,300.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	64,584,300.00	64,584,300.00	-	100%

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	872,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	872,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	872,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагат Отгон сумын Соёлын төвтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгон сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 04/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Отгон сумын Соёлын төв нь Хүн амыг соён гэгээрүүлэх, хувь хүн болон бүлэг хамт олны бүтээлч чадавхи, оюун санааны илэрхийллийн таатай нөхцлийг бий болгох, хүн амд соёлын үйлчилгээг чанартай, жигд хүртээмжтэй хүргэх, бүх нийтийн соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага.

Байгууллагын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Отгон сумын Соёлын төвийн нь Дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгон сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 500.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 68,120.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 600.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 400.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	519.9	237.2	-282.7
Бараа	9,524.4	12,101.6	2,577.2
Үндсэн хөрөнгө	74,384.2	63,383.8	-11,000.4
Нийт хөрөнгө	84,428.5	75,722.6	-8,705.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	84,428.5	75,722.6	-8,705.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	84,428.5	75,722.6	-8,705.9

Авлага дансны үлдэгдэл 282.7 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагчидтай холбогдсон авлагаа барагдуулсан байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,577.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, түлш шатах тослох материал, бусад хангамжийн материал дансдын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 11,706.6 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 1,706.2 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн, 10,835.6 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,000.4 мянган төгрөгөөр буурсан тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө олж бэлтгээгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,705.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 64,584.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төвлөрсөн төсвөөс 64,584.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 64,559.4 мянган төгрөгийг зарцуулж, 24.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтын дансанд өөрийн орлогоос 203.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд 203.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 2, оруулаагүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт төлбөр хүргүүлсэнийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 996.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.

4.4 Зөвлөмж : Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-ыг хэрэгжүүлж ажиллах талаар 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 1 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Татварын данстай холбоотой асуудал

- ✓ **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд 13,414.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс ибаримтын цахим бүртгэлтэй тулгахад 996.6 мянган төгрөгийн гүйлгээ нь и баримтгүй байгаа нь нотлогдлоо.
- ✓ **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т

"Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Отгон сумын Соёлын төв	1	1.0	-	-	-	-	-	-	1	1.0